



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 17 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/29

Баянгол

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн "а", 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Ногоон хөгжил-Цэмцгэр Шарга" хөтөлбөрийн хүрээнд хийгдэх тэнэмэл муур, нохой устгах ажлыг удирдан зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Гантулга /МЭҮТ-ийн мэргэжилтэн/

Гишүүд: Х.Даваацэрэн /МЭҮТ-ийн дарга/

Н.Ганзориг /Санхүү төрийн сангийн мэргэжилтэн/

2. Ажлыг 07 дугаар сарын 17-ны өдрөөс 08 дугаар сарын 01-ний дотор гүйцэтгэхийг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 17 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/30

Баянгол

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн "а", 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Ногоон хөгжил-Цэмцгэр Шарга" хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ундны худгийн тохижилт, засварын ажлыг удирдан зохион байгуулж хийлгэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Х.Төртулга /Засаг даргын орлогч/

Гишүүд: Б.Оюунтүлхүүр /Байгаль орчны байцаагч/

Л.Оюунбилэг /Нягтлан бодогч/

2. Ажлыг 07 дугаар сарын 17-ны өдрөөс 08 дугаар сарын 01-ний дотор хийлгэж дуусгахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 17 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/31

Баянгол

Нийтээр амрах баяр ёслолын өдрүүдэд
авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.1.6-ын "л", 29.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын үндэсний баяр наадмын өдрүүдэд ажиллах сумын хариуцлагатай эргүүл, жижүүрийн нэр, ажиллах өдөр, цагийн хуваарийг хавсралтаар баталсугай.
2. 2017 оны 07 дугаар сарын 08, 09-ний өдрүүдэд архи согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдахыг хориглосугай.
3. Албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хаалга цонх, эд хөрөнгийн бүрэн байдалд хяналт тавьж ажиллахыг байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.
4. Цаг агаарын болзошгүй аюулт үзэгдлийн сэрэмжлүүлэг мэдээг цаг алдалгүй сумын удирдлага, багийн Засаг дарга, иргэд, малчдад хүргэхийг цаг уурын ажиглагч /Г.Болормаа/-д даалгасугай.
5. Эргүүл жижүүрийг нэгдсэн удирдлагаар хангаж, архи согтууруулах ундаа худалдах, үйлчлэх цэгүүдэд хяналт тавьж ажиллахыг хэсгийн төлөөлөгч /Т.Гэндэнсүрэн/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

М.ТУНГАЛАГТАМИР

Сумын Засаг даргын 20¹⁷ оны ⁰⁷
дугаар сарын ⁰⁷-ны өдрийн ^{11/31}
дугаар захирамжийн хавсралт

ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН ХУВААРЬ

Д/д	Жижүүрийн нэр	Албан тушаал	Ажиллах өдөр	Ажиллах цаг	Хариуцах албан тушаалтан
1.	М.Золбаяр Д.Алтайбаатар	Сургуулийн захирал Ня-бо	07 сарын 08 07 сарын 12	09 ⁰⁰ –с 24 цаг	Т.Гэндэнсүрэн Ж.Сайнбилэг
2.	Х.Төртулга Б.Гантулга	Засаг даргын орлогч МЭҮТ-ийн мэргэжилтэн	07 сарын 09 07 сарын 13	09 ⁰⁰ –с 24 цаг	
3.	Г.Гантулга Б.Шинэхүү	Улсын бүртгэгч Байгаль хамгаалагч	07 сарын 10 07 сарын 14	09 ⁰⁰ –с 24 цаг	
4.	Д.Энхбаяр Н.Ганзориг	Соёлын төвийн эрхлэгч Санхүү төрийн сангийн мэргэжилтэн	07 сарын 11 07 сарын 15	09 ⁰⁰ –с 24 цаг	



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

20 17 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/32

Баянгол

┌ **Бэлчээр чөлөөлөх тухай** ─┐

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаантуг багийн Иргэдийн Нийтийн Хурлын 2017 оны 07 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор тус багийн өвөлжөө, хаваржааны бүс нутагт 06 дугаар сарын 15-аас 11 дүгээр сарын 01 хүртэл хугацаанд мал оруулах, бэлчээхийг хориглосугай.

2. Захирамжийг мөрдөж хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллахыг Улаантуг багийн Засаг дарга /Б.Гантулга/, Мал эмнэлэг, үржлийн тасгийн бэлчээр хариуцсан мэргэжилтэн /Б.Гантулга/, Улаантуг багийн иргэдэд даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг зөрчсөн иргэнд тухай бүр хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Байгаль орчны улсын байцаагч /Б.Оюунтүлхүүр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

М.ТУНГАЛАГТАМИР



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 17 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/33

Баянгол

Зээл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 4.5 дахь заалт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 08 дугаар тогтоол, Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 03 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад дурдсан 5 иргэнд журмын дагуу зээл олгохыг санхүүгийн албаны дарга /Н.Гэрэлмаа/, ня-бо /Л.Оюунбилэг/ нарт зөвшөөрсүгэй.

2. Зээл авсан иргэдтэй гэрээ байгуулж, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэхийг /Х.Төртулга/, төслийн явц, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг /Н.Ганзориг/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

М.ТУНГАЛАГТАМИР

Сумын Засаг даргын 20¹⁷ оны ⁰⁷
дугаар сарын ¹⁷-ны өдрийн ^{А/33}
дугаар захирамжийн хавсралт

№	Төслийн нэр	Төсөл санаачлагч	Санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн зээлийн хэмжээ
1.	"Шаргал цай" төсөл	А.Алтангэрэл	3 сая
2.	"Малжуулалт" төсөл	Б.Төмөр	2 сая
3.	"Эрчимжсэн мал аж ахуй" төсөл	Н.Эрдэнэ-очир	3 сая
4.	"Хятад мотоциклийн засвар үйлчилгээ" төсөл	Д.Баярсайхан	2 сая
5.	"Боломж" төсөл	Ч.Ганширэм	2 сая
Нийт дүн			12 сая



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 17 оны 07 сарын 17 өдөр

Дугаар A/34

Баянгол

Ургамал түүж, бэлтгэх хугацаа
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйл, Ойн тухай хуулийн 18, 38 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын нутаг дэвсгэрт ургадаг “Чонон хармаг”-ийг жил бүрийн 8 дугаар сарын 20-оос өмнө түүж бэлтгэхийг хориглосугай.
2. Тогтоосон хугацааг дагаж мөрдөхийг нийт иргэдэд үүрэг болгосугай.
3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны байцаагч /Б.Оюунтүлхүүр/, Байгаль хамгаалагч /Б.Шинэхүү/, Баянгол багийн Иргэдийн Нийтийн хурлын дарга Э.Баярцэнгэл, Засаг дарга /Г.Ган-Очир/ нарт даалгасугай.
4. Хориглосон хугацаанд хармаг түүж бэлтгэсэн иргэн, аж ахуйн нэгжид хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэж, арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчны байцаагч /Б.Оюунтүлхүүр/, Байгаль хамгаалагч /Б.Шинэхүү/, Хэсгийн төлөөлөгч /Т.Гэндэнсүрэн/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

М.ТУНГАЛАГТАМИР



72

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 17 оны 07 сарын 17 өдөр

Дугаар A/35

Баянгол

Цол олгох тухай

Монгол Улсын Баяр наадмын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.5, 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ардын хувьсгалын 96 жилийн ойн сумын баяр наадамд үзүүрлэсэн Чойжилсүрэнгийн Бат-Эрдэнэ, залуу бөхчүүдийн тойргийн барилдаанд түрүүлсэн Төртулгын Ариунболд, үзүүрлэсэн Жаргалын Мягмарзаяа нарт "Сумын начин" цол тус тус олгосугай.

ЗАСАГ ДАРГА

М.ТУНГАЛАГТАМИР



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 17 оны 07 сарын 26 өдөр

Дугаар А/36

Баянгол

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн “а”, 29.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх” /GRANT9187-MON/ төслийн хүрээнд хийгдэх ажлыг удирдан зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Х.Төртулга /Засаг даргын орлогч/

Нарийн бичгийн дарга: Б.Оюунтүлхүүр /Байгаль орчны хяналтын улсын байцаагч/

Гишүүд: Ц.Лувсанжамц /Аймгийн Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, хошууч /

Б.Гантулга /МЭҮТ-ийн мэргэжилтэн /

Г.Өлзийсайхан /ХХҮГ-ын мэргэжилтэн /

П.Лхагвабаатар /Сумын зохицуулагч /

Б.Шинэхүү /Байгаль хамгаалагч /

Багийн засаг дарга нар

2. /GRANT9187-MON/ төсөлтэй хамтран ажиллах, төслийн үйл ажиллагаанд хяналт тавих, төслийн үр өгөөжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүн /Х.Төртулга/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

М.ТУНГАЛАГТАМИР

C/barimt/zahiramj/2017

00700096



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/37

Баянгол

Хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалын 2.3 дахь заалт, Засаг даргын зөвлөлийн 2017 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 07 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын харъяат Эрдэнэцогтын Даваажаргал нь “Аймгийн арслан”, Баянмөнхийн Төрмөнх нь “Аймгийн начин” цол хүртсэн тул хүндэтгэл үзүүлсүгэй.
2. Хүндэтгэлийн арга хэмжээнд 950 000 төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргаж зарцуулахыг Санхүүгийн албаны дарга /Н.Гэрэлмаа/, нягтлан бодогч /Л.Оюунбилэг/ нарт зөвшөөрсүгэй.
3. Анхан шатны баримтыг бүрдүүлж, захирамжинд хавсаргахыг нярав /Б.Уранцэцэг/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР